



# КОРОНАВИРУС БА ЭДИЙН ЗАСАГ



УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН

Коронавирусын дэгдэлттэй холбогдуулан Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн төлөв байдлыг танилцуулъя.


ҮСХ-ноос 2020 оны 3-р сарын 13-ны өдөр тархаасан нийгэм, эдийн засгийн байдлын статистик мэдээллээр 2020 оны эхний 2 сарын байдлаар улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс

- нийт хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 11.2 хувиар,
- улсын төсвийн орлого 11.7 хувиар,
- экспорт 29.5 хувиар, импорт 10.4 хувиар,
- аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 14.2 хувь, тэр дундаа уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 23.8 хувь,
- агаарын тээврийн орлого 21.7 хувиар тус тус буурч, харин
- улсын төсвийн зарлага 42.7 хувиар өсжээ.



## 1. УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны нийт орлогыг 12.9 тэрбум төгрөг байхаар баталсан. Үүний 3.2 тэрбум төгрөгийг уул уурхайн салбарын орлого, 3.5 тэрбум төгрөгийг импорт, 5.1 тэрбум төгрөгийг эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлийн орлого, 1.1 тэрбум төгрөгийг татварын бүс орлогоос бүрдүүлэхээр тооцсон байна.



Өөрөөр хэлбэл, төсвийн орлогын гуравны нэгийг уул уурхайн бүтээгдэхүүн буюу нүүрс, зэсийн баяжмалыг БНХАУ-д экспортолж, бүрдүүлэхээр тооцжээ.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.5 их наяд төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.5 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 120.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2020 оны 2 дугаар сард 697.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 92.6(11.7%) тэрбум төгрөгөөр буурч, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 848.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 253.9(42.7%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 85.7 хувийг татварын орлого бүрдүүлж байгаа бөгөөд татварын нийт орлого 2020 оны эхний 2 сард 1.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 76.2 (5.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд нэмэгдсэн өртгийн албан татвар 70.3 (25.8%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 33.5 (23.6%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 19.1 (12.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1. Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого, сая төгрөг

	2019 он			2020 он		
	I	II	I-II	I	II	I-II
Нэмэгдсэн өртгийн албан татвар	121 263.5	151 537.2	272 800.7	198 799.9	3 696.0	202 496.0

НӨАТ-ын орлогын 96.7 хувийг ААНБ-ын татвар, 3.3 хувийг иргэдийн төлсөн татвар бүрдүүлсэн байна. НӨАТ-ын тайланг 2019 онд нийт 32.1 мянган ААНБ тушаасан бөгөөд тэдгээрийн 45.0 хувь нь худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлж байжээ.

НӨАТ-ын орлого 2020 оны 1-р сард 198.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 63.9 хувиар өсөж байсан бол энэ оны 2-р сард 3.7 тэрбум төгрөг болж 147.8 тэрбум төгрөгөөр буурчээ. Эхний 2 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 70.3 (25.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. НӨАТ-ын орлого ийнхүү огцом буурсан нь НӨАТ төлөгч ААНБ-ын орлого буурснаас шалтгаалжээ. Цагаан сарын баярыг энэ жил улс орон даяар тэмдэглэхийг хориглосон нь жижиг, дунд үйлдвэрлэл болон худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн нь харагдаж байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлагын өсөлтөд урсгал зардал 225.1 (20.4%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 115.0 (3.0 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн 2020 оны зарлагад хөрөнгийн зардлыг 2019 оноос 17.3 хувиар өсгөн 3.8 их наяд төгрөг байхаар тооцсон байна. Гэвч энэ оны эхний 2 сарын байдлаар хөрөнгийн зардал өмнөх оны мөн үеэс 3 дахин өссөн байна.

Их засварын зардал 1.8 (15.2%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч хөрөнгийн зардал өсөхөд барилга байгууламжийн зардал 99.2 (4.3 дахин) тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийн зардал 1.5 (58.2%) тэрбум төгрөг, бусад хөрөнгийн зардал 15.7 (2.5 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

## 2. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлж хөл хорио тогтоогоод буй энэ үед дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид хүнсний бүтээгдэхүүний тасалдал үүсгэхгүй төлөө хичээл зүтгэл гарган ажиллаж байна.

Үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын борлуулалт 2020 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 25.8 хувиар буурсан ба мод, модон эдлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, химийн бүтээгдэхүүн, тамхи, хувцас зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн борлуулалт 11.9 хувиас 57.9 хувь хүртэл буурсан байна.

Харин хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэлийн борлуулалт 33.8 хувь өсжээ. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2020 оны эхний 2 сард 257.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 22.8 (9.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөхөд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2.1 (6.1%) тэрбум төгрөгөөр, үр тарианы гурил, малын тэжээл үйлдвэрлэл 3.1(8.7%) тэрбум төгрөгөөр, хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8.5 (29.3%) тэрбум төгрөгөөр, ундаа үйлдвэрлэл (согтууруулах ундаа ороод) 20.3(20.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Харин мах, загас, ногоо, тос боловсруулалт өмнөх оны мөн үеэс 11.1(30.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар

Салбар	2019		2020*			2020* I-II 2019 I-II
	II	I-II	I	II	I-II	
	тэрбум төгрөг					хувь
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	88.3	234.5	129.0	128.4	257.4	109.7
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	8.3	35.9	11.5	13.3	24.8	69.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	15.7	34.1	18.7	17.5	36.2	106.1
Үр тарианы гурил, малын тэжээл	10.5	35.0	21.5	16.6	38.1	108.8
Хүнсний бусад бүтээгдэхүүн	12.8	28.9	19.1	18.3	37.4	129.3
Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	41.0	100.5	58.2	62.7	120.9	120.3

Үхэр, ямааны мах, савласан ногоон цай, жигнэмэг, нэг, хоёрдугаар гурил, гоймон, цэвэр ус, амтат ус, ундаа, жүүс, талх, нарийн боов, бялуу, тараг, аарц, бяслаг, шингэн сүү, спиртийн үйлдвэрлэл 2020 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 11.9 хувиас 6 дахин өссөн байна.

Харин архи, дээд гурил, хиаман бүтээгдэхүүн, шар айраг, бууз, банш, хонь, адууны махны үйлдвэрлэл 1.6-84.5 хувиар буурсан байна.


Хүснэгт 3. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2019		2020*			2020* I-II 2019 I-II хувь
		II	I-II	I	II	I-II	
Үхрийн мах	т	20.9	121.9	56.9	55.0	181.0	148.5
Хонины мах	т	315.1	841.0	389.5	138.2	527.7	62.7
Адууны мах	т	80.7	2 206.8	103.6	238.9	342.5	15.5
Ямааны мах	т	7.0	73.3	184.1	254.9	439.1	6.0 <sup>1</sup>
Хиаман бүтээгдэхүүн	т	413.1	856.1	374.2	422.6	796.8	93.1
Шингэн сүү	мян.л	2 503.1	6 204.3	3610.6	3 401.6	7 012.3	113.0
Тараг	мян.л	877.8	1 962.6	1138.3	1 125.9	2 264.1	115.4
Зайрмаг	мян.ш	4 146.3	6 809.8	2005.7	1 807.7	3 813.3	56.0
Аарц	т	55.9	110.1	37.7	91.1	128.8	116.9
Дээд гурил	т	1 911.2	8 132.0	4508.1	3 348.4	7 856.5	96.6
Нэгдүгээр гурил	т	8 121.2	24 577.3	15976.4	12 270.8	28 247.2	114.9
Хоёрдугаар гурил	т	590.5	2 568.1	2261.8	1 520.9	3 782.5	147.3
Талх	т	1 339.4	3 411.6	2220.6	1 857.4	4 078.0	119.5
Нарийн боов	т	1 515.1	3 359.0	1737.0	1 768.8	3 759.0	111.9
Бялуу	т	129.6	261.8	160.5	166.7	327.2	125.0
Жигнэмэг	т	111.9	142.2	128.3	116.4	244.7	172.1
Гоймон	т	624.2	1 310.5	976.7	759.1	1 735.8	132.5
Бууз, банш	т	219.5	484.1	192.1	191.7	383.8	79.3
Савласан ногоон цай	кг	6 835.2	17 209.3	14475.2	15 178.5	29 653.7	172.3
Спирт	мян.л	838.0	1 655.7	900.0	989.4	1 889.4	114.1
Архи	мян.л	1 858.3	4 560.2	2630.5	1 857.5	4 488.0	98.4
Шар айраг	мян.л	5 504.0	12 694.5	6694.2	4 131.8	10 826.0	85.3
Цэвэр ус	мян.л	3 836.4	9 412.9	5313.8	6 970.0	12 283.8	130.5
Амтат ус, ундаа	мян.л	7 597.3	19 648.3	10165.4	25 118.6	35 284.0	179.6
Жүүс	мян.л	4 498.0	10 233.9	6258.4	6 530.6	12 789.0	125.0

### 3. ИНФЛЯЦ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 2 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 1.2 хувь, өмнөх оны эцсээс 2.1 хувь, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар хувиар өссөн байна.

Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Инфляцын түвшин 2017 оны 2 дугаар сард 2.4 хувь, 2018 оны 2 дугаар сард 6.9 хувь, 2019 оны 2 дугаар сард 6.9 хувь гарч байсан бол 2020 оны 2 дугаар сард 6.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр буурсан байна.

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 17 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 36 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2020 оны 3-р сарын 19-ны өдрийн ажиглалтаар өмнөх долоо хоногоос 15 нэрийн барааны үнэ тогтвортой, 7 нэрийн барааны үнэ буурсан, 14 нэрийн барааны үнэ өсчээ.

≈ Үнэ тогтвортой	↓ Үнэ буурсан	↑ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> <li>Алтан тариа задгай, дээд (1,425₮)</li> <li>Алтан тариа задгай, 1-р зэрэг (1,181₮)</li> <li>Алтан тариа савласан, 1-р зэрэг (1,232₮)</li> <li>Сүү ХК 1л (2,672₮)</li> <li>Сүү ХК 05л (1,204₮)</li> <li>Тараг, Цөцгийтэй (2,456₮)</li> <li>Шар будаа (2,808₮)</li> <li>Цөцгийн тос, ОХУ (4,182₮)</li> <li>Ургамлын тос (3,439₮)</li> <li>Ногоон цай, Гүрж (1,544₮)</li> <li>Ямааны мах, ястай (8,000₮)</li> <li>Манжин (1,619₮)</li> <li>Сонгино (1,500₮)</li> <li>Алим, фүжи (4,133₮)</li> <li>Газ (1,300₮)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Алтан тариа савласан, дээд (1,520₮)</li> <li>Цагаан будаа (3,709₮)</li> <li>Хонины мах, цул (9,550₮)</li> <li>Дизель түлш (2,429₮)</li> <li>Аи-95 (2,198₮)</li> <li>Аи-76, 80 (1,648₮)</li> <li>Аи-92, 93 (1,771₮)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Алтан тариа савласан, дээдийн дээд (2,166₮)</li> <li>Алтан тариа савласан, 2-р зэрэг (924₮)</li> <li>Задгай сүү (1,900₮)</li> <li>Атар талх (1,300₮)</li> <li>Зууван чех (1,556₮)</li> <li>Элсэн чихэр (2,749₮)</li> <li>Хонины мах, ястай (9,889₮)</li> <li>Үхрийн мах, ястай (12,189₮)</li> <li>Үхрийн мах, цул (14,222₮)</li> <li>Адууны мах, ястай (9,375₮)</li> <li>Монгол төмс (980₮)</li> <li>Монгол лууван (1,853₮)</li> <li>Байцаа (1,933₮)</li> <li>Өндөг, ОХУ (340₮)</li> </ul>

Хонины ястай махны үнэ 2020 оны 03-р сарын 19-ны өдөр өмнөх долоо хоногтой харьцуулахад 189 төгрөгөөр (1.95%) өсөж, харин хонины цул махны үнэ 75 төгрөгөөр (0.78%) буурсан байна. Хонины ястай мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 8000 төгрөгөөр, харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 13500 төгрөгөөр худалдаалж байна.

Хүснэгт 4. Нэг килограмм хонины ястай махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10 430	10 045	9 700	9 640	9 095	7 710	7 635
2020	8 705	9 600	10 080*									

2020 оны 03 дугаар сарын III долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 10080 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 12106 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 560 төгрөгөөр (4.9%), үхрийн цул махны үнэ 890 төгрөгөөр (6.6%) тус тус өссөн байна. Үхрийн ястай мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 10000 төгрөг, харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 14000 төгрөг байна.

Хүснэгт 5. Нэг килограмм үхрийн ястай махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11 700	12 280	11 540	11 375	10 950	10 090	9 755
2020	10 535	11 415	12 106*									

Үнийн судалгааны сагс дахь нийт 373 нэр төрлийн бараа, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг. Энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн нөлөө 36.2 хувь байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 3.0 пунктээр өссөн байна.

Хүснэгт 6. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 2 дугаар сард

Үзүүлэлт	2018 II		2019 II		2020 II	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	6.9	100.0	6.9	100.0	6.4	100.0
Импортын барааны нөлөө	3.6	51.4	2.3	33.2	2.3	36.2

#### 4. ЭКСПОРТ, ИМПОРТ

Манай улс 2020 оны эхний 2 сард нийт 114 улстай худалдаа хийсэн бөгөөд нийт бараа эргэлтийн 55.9 хувийг БНХАУ эзэлж байна.

Нийт бараа эргэлт 1.5 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 410.4 (21.3%) сая америк доллароор буурахад БНХАУ-тай хийсэн нийт экспорт 24.4 хувиар, импорт 8.6 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Энэ нь өмнөд хөршид цагаан сарын баярын амралтыг дамнан үргэлжилсэн халдварт өвчний тархалттай шууд холбоотой байна.

Хүснэгт 7. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импорт, мян.ам доллар


	Хэмжих нэгж	2019 II		2020* I		2020* II		2020* II 2020* I	
		Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
Гурил	тонн	-	-	811.4	329.7	-	-	-	-
Улаан буудай	тонн	-	-	1 087.5	209.5	270.0	58.5	24.8	27.9
Гахайн мах	тонн	61.3	236.3	227.7	644.4	192.1	519.7	84.4	80.6
Шувууны мах	тонн	399.2	961.3	1 199.7	2 188.3	37.7	52.5	3.1	2.4
Өндөг	сая.шир	7.2	503.6	11.4	896.7	8.1	520.3	71.0	58.0
Төмс	тонн	1.1	3.4	-	-	-	-	-	-
Хүнсний ногоо	тонн	3 135.0	602	4 796.3	871.6	4 474.9	783.2	93.3	89.9
Жимс, жимсгэнэ	тонн	2 088.3	1 607.4	1 720.9	1 300.4	1 518.9	1 303.0	88.3	100.2
Хуурай сүү	тонн	128.0	299.4	282.9	1 006.7	282.2	1 015.2	99.8	100.9
Цагаан будаа	тонн	2 414.0	1 292.2	1 716.6	975.9	518.2	290.6	30.2	29.8
Ургамлын тос	тонн	963.9	882.6	1 136.0	1 032.4	1 408.7	1 277.3	124.0	123.7
Элсэн чихэр	тонн	2 405.1	1 085.6	6 574.6	2 705.0	4 715.8	2 041.2	71.7	75.5

Монгол Улс эрсдэлийн бүс нутгаас хүнсний бүтээгдэхүүн импортлохгүй байх шийдвэр гаргасантай холбогдуулан 2020 оны 2 дугаар сард гахай махыг 100 хувь, шувууны махны 99.2 хувь, наранцэцэгийн тосны 94.4 хувийг ОХУ-аас импортолж, цагаан будааны 36.5 хувийг ОХУ-аас, 47.3 хувийг Вьетнамаас, 11.3 хувийг Казакстанаас, элсэн чихрийн 61.7 хувийг Тайландаас, 18.9 хувийг БНЭУ-аас, 17.6 хувийг ОХУ-аас тус тус импортолсон байна.

Өмнөх сартай харьцуулахад ургамлын тосны импорт 272.7 тонноор өсөж, харин элсэн чихэр, цагаан будаа, шувууны мах, улаан буудай, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, гахайн мах, сүүний импорт 0.7 тонноос 1.9 мянган тонноор, өндөгний импорт 3.3 сая ширхгээр тус тус буурсан байна.

Экспорт 2020 оны эхний 2 сард 770.7 сая америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 322.9 сая америк доллароор буурсан байна. Нийт экспортын 83.0 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлдэг бөгөөд энэхүү бууралтад алтны экспорт 115.6 (59.0%) сая америк доллар, зэсийн баяжмалын экспорт 90.0 (29.1%) сая америк доллар, нүүрсний экспорт 104.8 (31.4%) сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 3. Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая америк доллароор, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



## 5. ААНБ, ИРГЭДЭД ОЛГОСОН НИЙТ ЗЭЭЛ

ААНБ, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 2 дугаар сарын эцэст 17.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 729.2 (4.0%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 108.6 (0.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.8 (50.7%) их наяд төгрөг нь иргэдийн, 8.6 (49.3%) их наяд төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллагынх байна.

Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 2 дугаар сарын эцэст 14.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 841.8 (5.5%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 7.4 (0.1%) тэрбум төгрөгөөр өсжээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 83.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр буурсан байна.

Хүснэгт 8. ААНБ, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангиллаар, сарын эцэст, тэрбум төгрөг

	2018		2019		2020*		2020*II 2019 II
	I	II	I	II	I	II	
Зээлийн өрийн үлдэгдэл	13 654.5	13 825.4	17 210.8	17 238.8	18 082.5	17 347.4	100.2
Хэвийн зээл	11 524.0	11 566.3	14 588.4	14 467.7	15 321.9	14 475.2	99.2
Хугацаа хэтэрсэн зээл	936.9	993.0	834.6	926.8	925.2	1 030.3	111.0
Чанаргүй зээл	1 193.6	1 266.1	1 787.9	1 844.3	1 835.4	1 841.9	103.2

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 2 дугаар сарын эцэст 1030.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 106.1 (11.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 103.5 (11.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 2 дугаар сарын эцэст 1.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 6.5 (0.4%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 2.4 (0.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна.

## 6. ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ

Валютын ханш өссөн боловч өмнөх онуудын 1, 2 дугаар сартай харьцуулахад өсөлтийн хувь саарсан байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш 2020 оны 2 дугаар сард 2756.52 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар, өмнөх сараас 0.4 хувиар суларсан байна. 2020 оны 3 сарын 18-ны байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах дундаж ханш 2769.17 төгрөг байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2020 оны 2 дугаар сард 43.15 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар суларч, өмнөх сараас 2.7 хувиар чангарсан байна. 2020 оны 3 сарын 18-ны байдлаар төгрөгийн рубльтэй харьцах дундаж ханш 35.73 төгрөг байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2020 оны 2 дугаар сард 394.13 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар суларч, өмнөх сараас 0.6 хувиар чангарсан байна. 2020 оны 3 сарын 18-ны байдлаар төгрөгийн юаньтай харьцах дундаж ханш 394.37 төгрөг байна.




Хүснэгт 9. Монголбанкнаас зарласан төгрөгийн гадаад валюттай харьцах сарын дундаж ханш, төгрөгөөр, жил бүрийн 2 дугаар сард

Үзүүлэлт	2018 I	2018 II	2019 I	2019 II	2020 I	2020 II	2020.III.18
Америк доллар	2 425.91	2 402.90	2 649.68	2 633.37	2744.38	2756.52	2769.17
Жилийн өөрчлөлт,%	-2.5	-3	9.2	9.6	3.6	4.7	
Сарын өөрчлөлт,%	-0.3	-0.9	0.5	-0.6	0.6	0.4	
Евро	2 956.04	2 967.65	3 027.41	2 988.53	3046.97	3010.28	3037.78
Жилийн өөрчлөлт, %	11.9	12.4	2.4	0.7	0.6	0.7	
Сарын өөрчлөлт,%	2.7	0.4	0.8	-1.3	0.5	-1.2	
Юань	377.36	380.19	390.38	390.81	396.46	394.13	394.37
Жилийн өөрчлөлт,%	4.6	4.7	3.4	2.8	1.6	0.8	
Сарын өөрчлөлт,%	2.3	0.8	1.9	0.1	2	-0.6	
Рубль	42.81	42.28	39.61	40.01	44.34	43.15	35.73
Жилийн өөрчлөлт,%	3	-0.3	-7.5	-5.4	11.9	7.8	
Сарын өөрчлөлт,%	3.1	-1.2	1.2	1	2.2	-2.7	

## 7. АГААРЫН БОЛОН ТӨМӨР ЗАМЫН ТЭВЭЭР

ДЭМБ-аас онц байдал зарласнаар олон улсын нислэгүүд цуцлагдаж, улсууд гаднын иргэдийг нэвтрүүлэхгүй байх шийдвэр гаргаж, Монгол Улс ч хилээр орох, гарах урсгалыг хязгаарлаад зогсохгүй дотооддоо хөл хорио тогтоогоод байна. Үүнээс шалтгаалан агаарын тээврийн салбарын орлого 2020 оны эхний 2 сард 48.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13.3 (21.7%) тэрбум төгрөгөөр, 2 дугаар сард 16.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 14.2 (45.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 4. Агаарын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар




Агаарын тээврээр зорчигчид 2020 оны эхний 2 сард давхардсан тоогоор 178.0 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 19.9 (10.1%) мянган хүнээр буурсан байна. Мөн агаарын тээврээр зорчигчид 2020 оны 2 дугаар сард 65.2 мянган хүн болж, өмнөх сараас 47.6 (42.2%) мянган хүнээр буурсан байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2020 оны эхний 2 сард 123.9 (69.6%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 10.8 (8.0%) мянган хүнээр буурсан байна.

Энэхүү бууралтад Улаанбаатар-Бээжин чиглэлийн зорчигчид 48.9 хувь, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн зорчигчид 33.2 хувь, Улаанбаатар-Бангкок чиглэлийн зорчигчид 27.9 хувь, Улаанбаатар-Хайлаар чиглэлийн зорчигчид 24.2 хувь, Улаанбаатар-Гонконг чиглэлийн зорчигчид 22.9 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хот хоорондын хөл хорио тогсооны улмаас төмөр замаар зорчигчдын тоо 2020 оны 2 дугаар сард 112.7 мянган хүн болж, өмнөх сараас 129.2 (53.4%) мянган хүнээр буурсан байна.

Зураг 5. Төмөр замын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Төмөр замын тээврээр (давхардсан тоо) 2020 оны эхний 2 сард 354.6 мянган хүн зорчиж, өмнөх оны мөн үеэс 25.4 (6.7%) мянган хүнээр буурсан байна.

Төмөр замын тээврээр зорчигчид буурахад орон нутгийн зорчигчид 21.3 (5.8%) мянган хүнээр буурсан нь нөлөөлсөн байна.

## 8. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Коронавирусын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэ оны 1-р улиралд хүмүүсийг олноор цугларахыг хориглон, амралт, сувиллын газрууд, өвлийн аялал жуулчлалын үйл ажиллагааг цуцалсан нь аялал жуулчлалын салбарт сөрөг нөлөөтэй.

Тэгвэл өмнө жилүүдийн статистикаас харахад Монгол Улсын хилээр 2019 онд гадаадын 636.9 мянган хүн орсны 90.6 хувь нь аялал жуулчлалын зорилгоор ирсэн байна.

2019 оны байдлаар нийт гадаадын зорчигчдын 13.9 хувь нь 1 дүгээр улиралд ирсэн бол 68.6 хувь нь 2 болон 3 дугаар улиралд иржээ. Үүнээс үзэхэд 1-р улиралдаа багтан коронавирусын тархалт намжиж, хилийн хориг тавигдвал сөрөг нөлөөлөл нь Монгол улсын аялал жуулчлалын салбарт харьцангуй бага байна.

### ДҮГНЭЛТ

Шинэ он гарснаас хойш тасралтгүй үргэлжилж байгаа байгалийн гамшиг, аюул осол, халдварт өвчний дэгдэлт нь дэлхийн эдийн засгийг нэлээд тодорхой бус байдалд хүргэж байна.

Манай улсын эдийн засгийн идэвх өвлийн улиралд сулардаг бөгөөд олон жилийн ажиглалтаар оны эхний улиралд үйлдвэрлэл, борлуулалт саарч, татварын орлого буурах хандлагатай байдаг. Ялангуяа махны эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалсан инфляц нэмэгддэг.

Үүнтэй зэрэгцэн энэ онд Ковид-19 буюу коронавирусын халдварын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээнээс шалтгаалан Монгол Улсын экспорт, импортын хэмжээ саарах, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого буурах төлөв байдал ажиглагдаж эхлээд байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.5 их наяд төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.5 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 120.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Энэ оны 2 дугаар сард улсын нэгдсэн төсвийн нийт орлого 697.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 11.7%-аар буурсан бол нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 848.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 42.7%-аар өссөн байна.

Энэ оны эхний 2 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс улсын нэгдсэн төсвийн орлого буурахад нэмэгдсэн өртгийн албан татвар 70.3 (25.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

НӨАТ-ын орлого огцом буурахад НӨАТ төлөгч ААНБ-ын орлого буурсан нь нөлөөлөв. Энэ онд улс орон даяар Цагаан сарын баярыг тэмдэглэхийг хориглосон нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн орлого багасах шалтгаан болсон.

Улсын нэгдсэн төсвийн гуравны нэгийг бүрдүүлдэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан нь төсвийн орлого тооцоолсон хэмжээнд хүрэхгүй болох эрсдэлийг дагуулж байна.

Дэлхий нийтийг хамраад буй халдварт өвчний тархалт манай улсын үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлж эхэлж байна. Нэн ялангуяа үйлдвэрлэлийн түүхий эд, материал болон сэлбэг, эд ангиа гаднаас импортолдог резин болон хуванцар бүтээгдэхүүн, хувцас, химийн бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, мод, модон эдлэл, тавилга үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 4.8 хувиас 44.5 хувиар буураад байна.

Үүнтэй уялдаад банкны системийн хэмжээгээр хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 2 дугаар сарын эцэст өмнөх сараас 11.5%-аар өссөн байна.

Харин халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлж хөл хорио тогтоогоод буй энэ үед дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид хүнсний бүтээгдэхүүний тасалдал үүсгэхгүй төлөө хичээл зүтгэл гарган ажиллаж, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2020 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 22.8 (9.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ДЭМБ-аас онц байдал зарласны дагуу хилээр орох, гарах урсгалыг хязгаарласнаас шалтгаалан агаарын тээврийн салбарын орлого 2020 оны 2 дугаар сард өмнөх сараас 45.7 хувиар буурсны дээр дотоодын хөл хорионы улмаас төмөр замаар зорчигчдын тоо 53.4 хувиар буурсан байна.

Харин мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлалын салбарт төдийлөн сөрөг нөлөө одоогоор гараагүй байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 21.3% буурсан нь БНХАУ-тай хийсэн нийт экспорт 24.4 хувиар, импорт 8.6 хувиар буурсантай холбоотой байна.

Валютын ханш өссөн боловч өмнөх онуудын 1, 2 дугаар сартай харьцуулахад өсөлтийн хувь саарсан байна.

Ирэх саруудад коронавирусын тархалтын эсрэг хэрэгжүүлж буй хөл хорио тогтоох арга хэмжээ үргэлжилбэл махны үнийн өсөлт болон импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн удаашралтай холбоотой инфляцын түвшин өсөх хандлагатай байна.

Улсын нэгдсэн төсвийн 2020 оны зарлагад хөрөнгийн зардлыг 2019 оноос 17.3 хувь өсгөн тооцсон ч 2020 оны эхний 2 сарын байдлаар хөрөнгийн зардал 3 дахин өссөн байна. Төсвийн орлогын бүрдэл сааралттай энэ үед зардлыг эрэмбэлж, төсвийн сахилга батыг улам чангатгах шаардлагатай байна.

Мөн коронавирусын эдийн засагт нөлөөлж эхлээд байгаа бодит байдалд үндэслэн аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд учрах эрсдэлийг багасгахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ҮНДЭСНИЙ ТООЦОО,  
ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ГАЗРЫН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА,  
ТҮҮВРИЙН АЛБА